



165

ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ

2020 оны 12 сарын 28 өдөр

Дугаар 23

Мандалговь

Үндсэн хөрөнгө бүртгэх зөвшөөрөл
олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.2, 77.3, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2020 оны 30 дугаар тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ийн 1 дүгээр зүйлийн 1.2, 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсгийг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

Нэг: Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардлын санхүүжилтээр Дундговь аймаг дахь Цагдаагийн газарт олгосон 5 нэр төрлийн 6 ширхэг 18,544,800 /арван найман сая таван зуун дөчин дөрвөн мянга найман зуу/ төгрөгийн өртөгтэй багаж, тоног төхөөрөмжийг үндсэн хөрөнгөд бүртгэхийг зөвшөөрсүгэй.

Хоёр: Дундговь аймаг дахь Цагдаагийн газрын дарга (Г.Наранбаатар)-д дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай.

- 2.1. Комисс томилон хөрөнгө хүлээн авч бүртгэх ажлыг байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналт дор холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;
- 2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;
- 2.3. Энэ тогтоолын биелэлтийг 2021 оны 1 дүгээр улиралд багтаан Орон нутгийн өмчийн газарт ирүүлэх;


Гурав: Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Аймгийн Засаг дарга (Ц.Мөнхбат)-д үүрэг болгосугай.

ДАРГА



С.ОД-ЭРДЭНЭ

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Тэргүүлэгчдийн 2020 оны 12 дүгээр сарын
28...ний өдрийн 13 тогтоолын хавсралт



Цагдаагийн газрын үндсэн хөрөнгөд бүртгэх хөрөнгийн мэдээлэл

№	Хөрөнгийн нэр	Хэмжих нэгж	Нэгж үнэ	Тоо	Дүн
1	Согтуурал хэмжих багаж	ш	1,460,800	2	2,921,600
2	Дрон камер	ш	4,680,000	1	4,680,000
3	Зөөврийн компьютер	ш	2,500,000	1	2,500,000
4	Согтуурал хэмжигч	ш	5,843,200	1	5,843,200
5	Зургийн аппарат /canon 80D/	ш	2,600,000	1	2,600,000
Тоног төхөөрөмжийн дүн				6	18,544,800